



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

**“Эрүүл орчин- Иргэдийн сайн сайхан” арга
хэмжээг 2023-2024 онд хэрэгжүүлэх
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 19 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан” арга хэмжээг 2023-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг тооцон төсөвт суулган хэрэгжүүлж үр дүнг тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралт



**“ЭРҮҮЛ ОРЧИН-ИРГЭДИЙН САЙН САЙХАН” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД
2023-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр

Багахангай дүүрэг

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага		Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт
				Үндсэн	Хамтран		
Нэг. Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах, ААНБ-ын үүрэг оролцоог дээшлүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр							
		1.1. Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон болох аяныг жил бүр зохион байгуулах	2023-2024	ИТХ	ААНБ-ууд	1,0	Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олны тоо нэмэгдсэн байна.
	Хүн амын дунд архи, согтууруулах ундааны хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг	1.2. Төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	2023-2024	ЗДТГ	ИТХ ААНБ-ууд	2,0	Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага дээшилж, гэмт хэрэг зөрчил гаргасан үзүүлэлт буурсан байна.

1	<p>тогтмолжуулж, нийгмийн ухамсрыг дээшлүүлэн, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд төрийн болон бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд сурталчлан, тайлагнаж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах</p>	<p>1.3. Дүүргийн аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагчдын дунд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах заалт тусгаж, үнэлж дүгнэх</p>	<p>2023-2024</p>	<p>ЗДТГ</p>	<p>ААНБ-ууд</p>	<p>Зөрчил гаргасан ААНБ-ын тоо буурсан байна. Хорт зуршлын талаарх мэдээлэл авсан ажилтан албан хаагчдын тоо нэмэгдсэн байна.</p>
	<p>1.4. Дүүргийн хэмжээнд бэлтгэгдсэн Аддиктологийн нийгмийн ажилтнуудаар дамжуулан үе шаттай сургалт зохион байгуулах</p>	<p>2023-2024</p>	<p>ЗДТГ Хороод ГБХЗХХ</p>	<p>ААНБ-ууд</p>	<p>Сургалтад хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.</p>	
	<p>1.5. Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, хүүхэд, залуучуудын хандлагыг өөрчлөх, эрүүл зөв амьдрах чиглэлийн сургалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн, зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн аян зохион байгуулах.</p>	<p>2023-2024</p>	<p>ГБХЗХХ ЭМТ ЦХ Насан туршийн боловсролын багш</p>	<p>ИТХ ЗДТГ Хороод ХЦС ТББ-ууд</p>	<p>Иргэдийн хандлагад эерэг өөрчлөлт гарч, хорт зуршлаас татгалзсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.</p>	
	<p>1.6. ХЦС, ХӨУБ-уудтай хамтран утаат болон электрон тамхинаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>2023-2024</p>	<p>ИТХ ЗДТГ ХЦС</p>	<p>ХӨУБ-ууд</p>	<p>Өсвөр үе, хүүхэд багачуудын дунд хорт зуршлаас сэргийлэх мэдээлэл дээшилсэн байна.</p>	
	<p>1.7. "Эр зоригийн хүч" ТББ үйл ажиллагааг дэмжиж,</p>	<p>2023-2024</p>	<p>ЗДТГ Эр зоригийн</p>	<p>ИТХ ГБХЗХХ</p>	<p>Төр, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага,</p>	

							бүлгийн хамтын сайжирсан байна.	ажиллагаа
Дэлхийн зөн ОУБ-тай хамтран чадавхжуулах, төсөл хэрэгжүүлэх								
1.8.Хорт зуршлаас татгалзах хүсэлтэй иргэд, хүүхэд, залуучуудыг зөвлөгөөн, аялал, цугларалт бусад арга хэмжээнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх	2023-2024	ИТХ ЗДТГ ГБХЗХХ	Хороод ААНБ-ууд	2,0			Хорт зуршилтай иргэдийн тоо буурсан байна.	тоо
1.9.Нийслэлээс хэрэгжүүлж буй "Итгэл", "Урам болон бусад төслийг хэрэгжүүлэх	2023-2024	ЦХ Хороод	ИТХ ЗДТГ	-				
1.10.Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн, ахуйн хүрээнд согтуугаар танхайрч удаа дараа эрүүлжүүлэгдсэн иргэдийг шүүхийн шийдвэрээр баривчлуулах, архины албадан эмчилгээнд хамруулах	2023-2024	Цагдааг ийн хэлтэс	Хороод	-			Хорт зуршлаас иргэдийн тоо нэмэгдсэн байна.	татгалзсан
1.11.Архины хамааралтай бөгөөд хамаарлаас ангижрах хүсэлтэй иргэдийг СЭМҮТ-ийн наркологийн тасгийн өдрийн эмчилгээ, үйлчилгээнд үе шаттай хамруулах	2023-2024	ЗДТГ ГБХЗХХ	ЦХ Хороод	-			Хорт зуршлаас иргэдийн тоо нэмэгдсэн байна.	татгалзсан

	<p>1.12.Архины хамааралтай иргэд, архидаг сонгуурснаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон төрийн байгууллагын болон төрийн, орон нутгийн өмчит байгууллагын ажилтнуудад Монголын АА нийгэмлэгийн Багахангай дүүрэг дэх "Бид хамтдаа" бүлэгтэй хамтран сургалтад хамруулах.</p>	2023-2024	ЗДТГ ЦХ ГБХЗХХ	ААНБ-ууд	-	Иргэдийн хандлагад эерэг өөрчлөлт гарч, мэдээ мэдээлэл авсан иргэдийн тоо нэмэгдсэн байна.
	<p>1.13 Гэмт хэрэг зөрчил, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр жишиг үйл ажиллагаа явуулж буй аймаг, орон нутагт туршлага судлах</p>	2023-2024	ИТХ ЗДТГ	ГБХЗХХ ЦХ ААНБ-ууд	2,0	Жишиг үйл ажиллагааг дүүрэгт хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ.
	<p>1.14.Гэмт хэрэг, зөрчил, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл болон "Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан" арга хэмжээний хүрээнд гарсан ололт, амжилтыг дүүргийн вэб сайт, "Багахангай-Хэвлэл мэдээлэл" пэйж хуудас, ААНБ-ын facebook хуудсаар сурталчлан, шторк, контент бэлтгэн иргэд, олон нийтэд түгээх</p>	2023-2024	ИТХ ЗДТГ ЦХэлтэс ГБХЗХХ	Хороод ААНБ-ууд	1,0	Иргэд, олон нийтэд мэдээлэл түгээгдсэн байна.

Хоёр. Ажлын байраар хангах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, тусламж дэмжлэгт хамруулах чиглэлээр

Хорт зуршлаас бүрэн татгалзсан иргэдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, дамжаанд хамруулан, байнгын болон түр ажлын байраар хангах, жижиг, дунд бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэн, төсөл, хөтөлбөрт хамруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх	2.1.Хорт зуршлаас бүрэн татгалзсан иргэдийг ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулах 2.2.Хорт зуршлаас татгалзаж буй иргэдийг түр болон байнгын ажлын байраар хангах 2.3.Жижиг дунд бизнес эрхлэх, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулах 2.4.Хорт зуршлаас татгалзах хүсэлтэй, татгалзсан иргэдийг олон улсын, хандивлагч байгууллагын төсөл хөтөлбөр, хүмүүнлэгийн тусламж дэмжлэгт хамруулах	2023-2024	ХХҮХ	ЗДТГ Хороод	-	Зөвлөгөө мэдээлэл авсан иргэд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан байна.	
2		2023-2024	ХХҮХ ЖДҮДТ	ЗДТГ Хороод	-	Ажлын байраар хангагдсан байна.	
		2023-2024	ХХҮХ	ЗДТГ ЖДҮДТ Хороод	-	Ажлын байр бий болж, өрхийн орлого нэмэгдсэн байна.	
		2023-2024	ЗДТГ Хороод	УЗХороо	5,0	Иргэд тусламж дэмжлэгт хамрагдаж өрхийн орлого нэмэгдсэн байна.	
Гурав. Эрүүл орчин бүрдүүлэх чиглэлээр							
	3.1.Нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайн гэрэлтүүлэг болон хяналтын камерын тоог нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах	2023-2024	ИТХ ЗДТГ	ЦХ Багахангай тохижилт Багахангай гэрэлтүүлэг ОНӨААТҮГ	1,0	Гэмт хэрэг, зөрчлийн тоо буурч, иргэдийн ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдэнэ.	

Иргэдийн аюулгүй ажиллаж орчны бүрдүүлж, орчны аюулгүй байдлыг хангах	3.2. Үерийн ус зайлуулах сувгийг засварлах	2023-2024	ЗДТГ	Багахангай тохижилт ОНӨААТҮГ	478,0	Албан байгууллага орон сууцны байрнуудын зоорийн давхар усанд автахаас сэргийлнэ
	3.3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн орчны аюулгүй байдлыг хангуулах үзлэг шалгалтыг тогтмол зохион байгуулах, холбогдох арга хэмжээ авах	2023-2024	ЗДТГ	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ	5,0	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн орчны аюулгүй байдал хангагдана
	3.4. Хүүхдийн тоглоомын талбайн орчны аюулгүй байдлыг хангах	2023-2024	ЗДТГ	Багахангай тохижилт ОНӨААТҮГ	5,0	Хүүхдийн тоглоомын талбайн орчны аюулгүй байдлыг хангагдана
	3.5. Орон сууцны байрнуудын орчны засвар хийж, гэрэлтүүлгийн асалтыг сайжруулах	2023-2024	ЗДТГ	ХААА Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ СӨХ-д	301,0	Амьдрах орчин сайжирна.
	3.6. Согтууруулах тамхи худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт тавих	2023-2024	ЦХ ЗДТГ	Хороод	-	Стандарт хэрэгжилт хангагдсан байна.